

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2022 оны 07 дугаар сарын мэдээ

2022.07.25

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр: Сум байгуулагдсаны 97 жилийн ойгоор төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор 14 иргэн, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар 2 иргэн шагнагдсан мөн ажил үйлсээрээ шалгарсан 4 иргэнийг сумын “ИТХ-ын даргын хүндэт” өргөмжлөлөөр тус тус шагнагдсаныг баярын хурлаараа гардуулсан.

Сүхбаатар аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойд 5 багт хандивын арга хэмжээг санаачилан зохион явуулж 10.0 сая төгрөгийг хүлээлгэж өгсөн.

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Тухайн сард дээд газраас 7 албан бичиг ирсний 5 нь хариутай, 2-нь хугацаандаа, 3-нь хугацаа болоогүй байна.

Тулгар төрийн 2230, 2231 жил, Их Монгол улс байгуулагдсаны 815, 816 жил, Ардын хувьсгалын 100,101 жил, сум байгуулагдсаны 96,97 жилийн ойн үндэсний их баяр наадмыг амжилттай зохион байгуулсан.

Баяр наадмаар Улаанбаатар хот болон 4 аймгийн 8 сумын 604 хурдан хүлэг уралдаж шандасаа сорилоо. Эрийн гурван наадмын нэг болох сурын харваад 12 иргэн оролцож цэц мэргэнээ сорисон. Хүчит 64 бөх барилдснаас аймгийн харцага А.Анхбаяр түрүүлсэн.

Нэгдсэн хогийн цэгийг цэгцлэх ажлын тендерт гүйцэтгэгчээр шалгарсан Элемент медиал ХХК -тай гэрээ байгуулан нэгдсэн хогийн цэгийг цэгцлэх ажил 40% -тай хийгдэж байна.

Хоёр: Төсөв санхүүгийн чиглэлээр: 2022 оны орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ Шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн тавьж илгээлээ. Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэг, Тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилтыг хуваарийн дагуу эхний 7 сар бүрэн олгогдсон.

Байгууллагын өр авлага ,төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч ЗГУСХС бүрэн мэдээлсэн. Статистикийн байгууллагад хүргүүлэх сар улирлын мэдээ тайланг хугацаанд нь гаргаж явуулсан.

Төсөвт газрууд 2022 оны эхний хагас жилийн тайлан мэдээгээ хийж Э-баланс программд шивж оруулсан, мөн 2023 оны төсвийн төсөлөө боловсруулж санхүү төрийн сангийн хэлтэст тушаасан.

2022 оны Хөдөө аж ахуйн,орон нутгийн өмчийн ээлжит тооллогийг комиссын бүрэлдэхүүний хамт программд шивж статистикийн хэлтэс тушаахад бэлэн болгосон. Төсөвт байгууллагуудын цалин болон бусад гүйлгээг төлбөрийн хүсэлтийн дагуу цаг хугацаанд нь санхүүгийн программд шивж гүйцэтгэн төлбөрийн хүсэлт болон баримтыг хуулгатай тулган архивын нэгж үүсгэн ажиллаа.

Төсөвт байгуулага, татварын орлогын дансанд гарын үсгийн баталгааг авч натиротоор баталгааж, цахим мэдээллийн системд оруулж ажиллаа.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд: “Тогтвортой амьжиргаа 3” төслөөс ОНХСангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтэд бэлтгэх ажлын хэсэг тус суманд ажиллаж багийн засаг дарга, ОНХС хариуцсан ажилтануудад сургалт зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Соёл: Тулгар төрийн 2230, 2231, Их Монгол улс байгуулагдсаны 815,816, Үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээн мандуулсаны 110,111, Ардын Хувьсгалын 100, 101 жил Баяндэлгэр сум үүсгэн байгуулагдсаны 96,97 жилийн ойн баяр наадмын баярын хурал, нээлт, хаалтын үйл ажиллагаа, болон бусад соёл урлагийн үйл ажиллагааг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулж ажиллаа.

Баярын хурал, шагнал гардуулах ажиллагаанд зориулсан “Би Монгол хүн” хүндэтгэлийн тоглолт зохион байгууллаа. Хамрагдагсад-140 иргэн.

Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор Үдшийн цэнгүүн 3 удаа зохион байгууллаа. Хамрагдагсад-183 иргэн.

Баяр наадмын соёл урлагийн хөтөлбөрийг боловсруулж “Би Монгол хүн” хүндэтгэлийн тоглолт, баяр наадмын нээлтийн үйл ажиллагааг 60 хүний бүрэлдхүүнтэй зохион байгууллаа.

Мөн “Сайхан хос”, Уурга шүүрэх тэмцээн, “Дарьганга өв соёл”-ын отог зохион байгуулж 6 багийн ард иргэд Дарьганга үндэсний хэлхээ тоонотой гэр барьж иргэдийн гар дээр хадгалагдаж буй өв болон дарьганга үндэсний хоол хүнснийг хийж зан заншлын үзүүлбэрүүдийг үзүүлсэн “Нутгийн соёл” үзэсгэлэн зэргийг зохион байгууллаа.

Номын сангийн үйлчилгээ: Байнгын уншигч 42, ирэгсэд 182 хүнд 289 ном гэрээр олгож 11 хүнд утсаар болон амаар лавлагаа өгч 3 татгалзал бүртгэлээ.

Баяндэлгэр Соёлын төв цахим группт уран зохиол-2022, соёлын өв-2022, судар эгшиглэн-2022, дотоод үйл ажиллагаа-2022 булангуудыг хөтлөн нийт 18 мэдээлэл орууллаа.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчин: Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх анхан шатны бэлтгэл ажил 1000 багш бэлтгэх сургалтад хамрагдлаа.

Ногоон байгууламжийн усалгаа арчилгааг хариуцан ажиллаж модны ургалтын хувь 88 хувьтай байна.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажилд сумын хэмжээнд 1 байх ашиглалтын лиценз эзэмшигч Талын элч ХХК-г татан оролцуулж, 20 000 000 төгрөгийн хөрөнгө оруулалт нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлжээ. Тус санхүүжилтээс ногоон байгууламжийн 60 метр хашааг будаж, хашаан дах хөл газрын ургамлыг

цэвэрлүүлээд байна. Мөн ногоон байгууламжийн туслах ажил, үйлчилгээнд нийтийг хамарсан ажлын 4 иргэнийг хамруулж урамшуулыг шийдэн ажиллаж байна.

Хөдөө аж ахуй Сумын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг 7 хоног бүрийн 1 дэх өдөр ХХААХҮЯ –нд программд шивж илгээдэг.

2022 оны 07 дугаар сарын 24 -ны байдлаар сумын жишсэн дундаж хүн амын хоногийн хэрэгцээнд харьцуулснаар гурил – 63 хоног, гурилан бүтээгдэхүүн – 4 хоног, төрөл бүрийн будаа – 61 хоног, хуурай сүү – 26 хоног, өндөг – 2 хоног, ургамлын тос – 11 хоног, төмс – 8 хоног, хүнсний ногоо – 2 хоног, элсэн чихэр -22 хоног, давс – 65 хоног, ус – 4 хоногийн нөөцтэй байна.

Өрхийн тариалан эрхлэлтийн тариалалтын мэдээг ХАА – 7 маягтаар өрх тус бүрээр статистикийн хэлтэст программд шивж илгээсэн.

Үүнд: 4 төрийн байгууллага, 22 иргэн өрхийн хэрэгцээнд зориулж, 1,36 га талбайд төмс, 1,13 га талбайд хүнсний ногоо тариалсан.

Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, Баяндэлгэр сум байгуулагдсаны түүхт 97 жилийн ойн баяр наадамд 103 – азарга, 126- их нас, 83- хязаалан, 112- соёолон, 87 шүдлэн, 93- дааган насны морьдын бүртгэлийг 2022 оны 07 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд хийж, баяр наадмын өдрүүдэд барианд орсон эхний 20 морины цувааг хөтөлж, бүртгэлтэй тулган баталгаажуулсан.

Нэгтгэсэн: ХЭЗХ-мэргэжилтэн

Ж.Долгорсүрэн